



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны ᠮ сарын 17 өдөр

Дугаар А/24

Хэрлэн сум

Бор-Өндөр цогцолбор сургуулийн ангилалд  
өөрчлөлт оруулж, шинээр байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.7 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны газрын дүгнэлтийг үндэслэн Бор-Өндөр сумын Бор-өндөр цогцолбор сургуулийн ангилалд өөрчлөлт оруулан дунд, ахлах ангийн сургалтын үйл ажиллагааг явуулахаар өөрчилж, Бор-Өндөр бага сургуулийг шинээр байгуулсугай.

2.Өөрчлөлт оруулахтай холбогдуулан хэрэгжилтийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, бага болон цогцолбор сургуулийн багш, удирдлагыг арга зүйн зөвлөгөө, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахыг Бор-Өндөр сумын Засаг дарга (П.Чинбат)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ